



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@jaac.mn, Вэб сайт: http://jaac.mn

2021-10-05 № 05/10812
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Хэнтий аймгийн Соёлын хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Төмөрийн Зулбаатарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт зэасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдээгүй байгаа нь, мөн Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д " төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл энэ хуулийн 16.1-д заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс" сонгон шалгаруулж томилно гэж заасныг тус тус зөрчихөөр байна.

Иймд Төрийн албаны тухай хууль болон нэр дэвшсэн тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан этгээдийг нийтийн албанд томилуулахаар нэр дэвшүүлж, дээрх хууль болон өөрийн салбарт мөрдөгдөж буй дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР